



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2020/208/СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2020 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Майцэцэг

Утас: 70273463 Цахим хаяг: maitselsetg@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: gbayan999@audit.gov.mn



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ЭМЯ, ЭМГ	Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн газар
НЭМҮТ	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
МГТ	Мөнгөн гүйлгээний тайлан
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НХМаягт	Нэг хэвийн маягт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	20

Аудитын гэрчилгээ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, Имайл: tuvaudit.gov.mn

2020-03-06 № 01/93
таний -ны № -т

ТӨВ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА С.МОНХТУЯА ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохицой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дунд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланда тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланда санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

19020106

D 2020/2020 он/ALBAN

BICHIG

Аудитын тайлан

2.1. Оршил

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрүүл мэндийн газрын дарга С.Мөнхтуяа танд танилцуулж байна

Энэхүү тайланда үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц запруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зерчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлзээ.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020.01.25-аас 2020.02.21-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2020.01.24-ны өдрийн 1/69 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бodoх бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь Хүн амд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй, чанартай хүргэснээр орон нутгийн хөгжил, амьдралын чанарт дэвшил гарч, эрүүл мэндийн хөгжлийн гарц бий болно. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

2019 оныг ЭМЯ-аас "Инээмсэглэл эерэг хандлага" уриаг хэрэгжүүлэхээр 4 чиглэлийн арга хэмжээг 97.5%-тай гүйцэтгэж, Аймгийн ЗДТГ-аас "Бүтээн байгуулалт-хөрөнгө оруулалт" жилийн урианы 6 арга хэмжээг 100% хэрэгжүүлсэн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол Улсын хууль

- Төсвийн тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

Засгийн газрын тогтоол

- 2019 оны 5 дугаар тогтоол "Журам батлах тухай"
- 2019 оны 6 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"
- 2019 оны 24, 25 дугаар тогтоолууд

- 2019 оны 271 дүгээр тогтоол "Журам шинэчлэн батлах тухай"
- 2019 оны 275 дугаар тогтоол "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай"
- 2019 оны 276 дугаар тогтоол "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай"

2.5. Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланда материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Төв аймгийн Эрүүл мэндийн газар санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бodoх бүртгэлийн "Acolous" программ хангамж ашигладаг байна.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайланийн аудит дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд (/Дунд) гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт (Үр нөлөөтэй) гэж үзлээ

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Төв аймгийн Эрүүл мэндийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 33 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дунд үндэслэн 11 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүү үр дүнгийн тайлангийн Нийт зардлыг сонгов.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийг дунд гэж үнэлж байгаатай холбоотой юм.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны нийт зардал 2,030,846.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 20,308.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,695.6 мянган төгрөгөөр буюу 5.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	112,846.5	92,774.6	-20,071.9
Үндсэн хөрөнгө	898,766.1	973,533.6	74,767.5
Нийт хөрөнгө	1,011,612.7	1,066,308.2	54,695.6
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,011,612.7	1,066,308.2	54,695.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,011,612.7	1,066,308.2	54,695.6

Бараа материалын дансны үлдэгдэл 20,071.9 мянган төгрөгөөр буурсан байгаа нь хугацаа дууссан вакцин устгалд оруулсан нь голлох шалтгаан болсон байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 74,767.5 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-аас 150,500.0 мянган төгрөгийн өртөгтэй 2 автомашин хандивлаж, 5,420.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан нь нелөөлжээ.

Үндсэн хөрөнгө тооллогоор дутагдсан 1,000.0 мянган төгрөг, акталсан 71,654.0 мянган төгрөгийн хөрөнгө данснаас хасагдсан байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилтийн дансаар: Хандив тусламжаар Төв аймгийн Эрүүл мэндийн газар нь тайлант онд орлого төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдаагүй боловч Дээд шатны төсвийн захирагчаас болон аймгийн Засаг дарга гэх мэт 7 аж ахуйн нэгжийн байгууллагаас төсөл хөтөлбөр, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 102,830.2 мянган төгрөгийн нэмэлт орлогыг бүрдүүлж, түүнээсээ төсөл хөтөлбөр, удирдамжийн дагуу 102,726.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 104.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
ЗГНХ, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		13,032.0		
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		30,780.8		
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		59,017.4		
Нийт дүн		102,830.2		

Орлогыг төлөвлөлтөд тусгуулах шаардлагатай байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 9 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 2 эрсдэл нэмж тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 116,996.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 13,319.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 102,677.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байхад 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 103,677.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, хүргүүллээ. Үүнд:

1. Тооллогоор дутагдуулсан 1,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий 50ш ном дутагсаныг Ажиллагсадтай холбогдох авлагаар бичилт хийн данснаас хасаж, энэхүү авлагаа бусад хангамжийн материалд 10ш ном бүртгэлд авч, зарлага болгон хаасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл 73.1.4-д “үнэ бүхий зүйлийн хэвийн хорогдлын нормоос хэтэрсэн дутагдал, гэмтлээс гарсан хохирлыг тухайн үеийн зах

зээлийн дундаж үнээр бодож гэм буруутай хүмүүсээр төлүүлнэ..." заалт, мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271 дүгээр тогтоолын 6 дугаар зүйлийн 6.2.2 "Ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад хэн нэгний буруутай үйлдлээс болж эвдэрч гэмтэн цаашид зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулан буруутай этгээдээр хохирлыг барагдуулсан тохиолдолд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шийдвэрээр данснаас хасна" заалттай нийцэхгүй, Бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт, албан шаардлага өгөх, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2016 оны A/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах, акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7-д "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" гэсэн заалтыг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 102,677.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Үндсэн хөрөнгийг худалдан аваходаа болон дутагдуулсан хөрөнгийг данснаас хасахдаа байгууллагын өмч хамгаалах байнгын комисс болон даргын тушаал шийдвэр гараагүй, элэгдлээрээ өртгөө бүрэн нехсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019.06.18-ны өдрийн 271 дүгээр тогтоолыг хэрхэн мөрдөж байгаа байдал

Төсөл хөтөлбөрийн арга хэмжээгээр санхүүжигдэн хэрэгжиж байгаа зардлуудыг эрх зүйн акт, тушаал шийдвэрийг үндэслэн зарцуулж, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан НӨАТ-ын цахим төлбөрийн баримтыг үндэслэн санхүүгийн гүйлгээг баримтжуулсан эсэх асуудлыг дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудлаар тодорхойлов.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэд нийцлийн аудит хийгдэж байгаа тул асуудлын бүртгэл хөтлөн баримтжуулсан болно.

Үүнд: Төв аймгийн Эрүүл мэндийн төв нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй учраас тус байгууллага шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх Төсөв/гүйцэтгэлийн чиглэлийн 49 мэдээлэл, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 39 мэдээлэл, Бусад 5 төрлийн 61 мэдээ, мэдээллээс цаг хугацаанд нь 144 мэдээллийг хугацаанд нь , 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 1 мэдээллийг байршуулаагүй хугацаа хүлээж байна. Шилэн дансны хэрэгжүүлэлт 97,3 хувьтай хэрэгжсэн байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 7.500.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 5,009.7 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан гэж Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019.06.13-ны өдрийн 1/609, 2020.01.24-ний өдрийн 1/69 тоотуудаар ирүүлсэн байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бodoх бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бodoх бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нелеөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлангийн хугацаанд 9 байгууллагатай холбоотой 18,350.4 мянган төгрөгийн санхүүгийн гүйлгээг НХМаягт ТМ-5 ebarimt -аар баримтжуулаагүй байна.

1.2. Эрсдэл:

Худалдан авалтыг албан ёсны бус баримтаар баримтжуулж, бэлтгэн нийлүүлэгч
байгууллагын борлуулалт буурч, татварын орлого буурах үр дагавартай

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан НХМаягт ТМ-5 ebarimt
-нд үндэслэн санхүүгийн гүйлгээг баримтжуулах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Нийт 84.326.7 мянган төгрөгийн орлогыг захиран зарцуулахдаа эрх зүйн акт тушаал
шийдвэр гаргалгүй төсөл, удирдамжийг үндэслэн шууд зарцуулж байна

2.2. Эрсдэл:

Төсөл, хөтөлбөрийн санхүүжилтүүдийн эх үүсвэрийг тогтооход хүндрэлтэй бөгөөд,
зориулалтын дагуу зарцуулалтад хяналт тавих боломжгүй байдал үүсэж байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж,
зарцуулах; Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2."төсвийн иж бүрэн, үнэн
зөв байдлыг хангасан байх" зарчмыг хэрэгжүүлэх

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 6
дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талаархал илэрхийлье.

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТИЙН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ Огноо:

Т.МАЙЦЭЦЭГ Огноо:

Г.БАЯНЖАРГАЛ Огноо:.....

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		112,846,521.13	92,774,572.13
35 БАРАА МАТЕРИАЛ		112,846,521.13	92,774,572.13
351 Түүхий эд материал		64,825,154.21	38,101,830.93
35110 Тусгай зориулалттай материал		2,375,700.00	2,375,700.00
35130 Эм боох материал		62,449,454.21	35,726,130.93
354 Хангамжийн материал		48,021,366.92	54,672,741.20
35410 Бичиг хэргийн материал		662,180.00	1,519,500.00
35420 Аж ахуйн материал		-	142,000.00
35440 Түлш, шатах тослох материал		1,543,100.00	2,816,500.00
35450 Барилтын засварын материал		5,009,700.00	5,009,700.00
35470 Бусад хангамжийн материал		40,806,386.92	45,185,041.20
2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	898,766,148.82	973,533,645.32	
39 ҮНДСЭН ХӨРӨНГӨ		898,766,148.82	973,533,645.32
392 Биет хөрөнгө		784,721,148.98	859,508,645.52
39201 Барилга, байгууламж, орон сууц		618,815,865.55	618,815,865.55
39202 Хуримтлагдсан элэгдэл		(33,417.85)	(23,055,862.69)
39203 Авто-тээврийн хэрэгсэл		157,518,256.00	286,183,256.00
39204 Хуримтлагдсан элэгдэл		(105,737,578.44)	(108,147,660.66)
39205 Машин тоног төхөөрөмж (компьютер)		227,884,193.18	197,165,197.32
39206 Хуримтлагдсан элэгдэл		(160,523,744.28)	(148,771,574.02)
39207 Тавилга, аж ахуйн эд хогшил		117,723,631.60	104,044,347.36
39208 Хуримтлагдсан элэгдэл		(80,144,325.98)	(74,943,192.54)
39217 Ном		9,218,269.20	8,218,269.20
393 Биет бус хөрөнгө		114,044,999.84	114,024,999.80
39301 Програм хангамж		2,057,500.00	2,057,500.00
39302 Хуримтлагдсан элэгдэл		(1,937,500.16)	(1,957,500.20)
39303 Бусад биет бус хөрөнгө		113,925,000.00	113,925,000.00
3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН Ш=I+II	1,011,612,669.95	1,066,308,217.45	
5 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,011,612,669.95	1,066,308,217.45	
51 Засгийн газрын хувь оролцоо		1,011,612,669.95	1,066,308,217.45
511 Засгийн газрын оруулсан капитал 'Засгийн газрын сан' орон нутгийн сан		1,097,766,471.77	1,097,766,471.77
51101 Өмч: - төрийн		983,841,471.77	983,841,471.77
51106 Эздийн өмчийн бусад хэсэг		113,925,000.00	113,925,000.00
512 Хуримтлагдсан үр дүн		(326,793,099.06)	(270,919,461.77)
51210 Өмнөх үсийн үр дүн		(326,793,099.06)	(325,615,009.27)
51220 Тайлант үсийн үр дүн		-	54,695,547.50
51300 Хөрөнгийн дахин үзэлгээнд зөрүү		240,639,297.24	239,461,207.45
6 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,011,612,669.95	1,066,308,217.45
VI=IV+V			

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Узүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,971,595,492.90	2,085,541,828.63
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	151,335,945.90	499,263,198.63
120	Нийтлэг татварын бус орлого	149,835,945.90	348,763,198.63
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	149,835,945.90	348,763,198.63
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	149,835,945.90	348,763,198.63
122	Тусlamжийн орлого	1,500,000.00	150,500,000.00
122001	Хандив тусlamж /дотоод/	1,500,000.00	150,500,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	1,820,259,547.00	1,586,278,630.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,754,475,500.00	1,483,448,400.00
131001	Ургал уйл ажиллагааны санхүүжилт	1,754,475,500.00	1,483,448,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,784,047.00	102,830,230.00
131103	ЗГНХ, ЗДНХеренгэ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,760,000.00	13,032,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,000,000.00	30,780,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,024,047.00	59,017,480.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,998,105,739.14	1,663,011,337.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,998,105,739.14	1,663,011,337.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	965,864,890.14	947,604,474.26
2101	Цалин хэлс болон нэмэгдэл урамшил	450,847,306.00	479,625,433.00
210101	Үндсэн цалин	450,847,306.00	479,625,433.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,273,842.00	60,837,319.00
210201	Тэтгэврийн даатгал	36,115,877.00	41,586,822.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,716,344.00	4,892,569.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,601,988.00	3,878,214.00
210204	Ажилгүйллийн даатгал	894,513.00	952,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,945,120.00	9,527,014.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮТ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,851,157.00	77,974,199.00
210301	Гэрэл, цахилгаан	5,841,235.00	6,389,060.00
210302	Түүш, халаалт	67,480,240.00	67,480,247.00
210303	Цэвэр, бохир ус	3,529,682.00	4,104,892.00
2104	Хангамж, бараа материалын зардал	68,527,178.00	64,723,613.72
210401	Бичиг хэрэг	8,372,621.00	4,999,930.00
210402	Тээвэр, шатахуун	53,656,249.00	46,667,880.00
210403	Шуудац холбоо, интернэтийн төлбөр	3,016,488.00	2,289,938.00
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэргэгчийн устгал, ариутгал	150,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,331,820.00	5,832,320.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	4,813,545.72
2105	Нормативт зардал	197,464,167.08	55,942,822.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	197,464,167.08	55,942,822.10
2106	Эд хогшил, ургал засварын зардал	10,381,500.00	27,731,810.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	705,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	770,100.00	00.00
210604	Ургал засвар	9,611,400.00	27,026,810.00
2107	Томилолт, зочны зардал	9,017,700.00	10,943,700.00
210702	Дотоод албан томилолт	9,017,700.00	10,943,700.00

**Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		6,194,860.00	8,694,348.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	720,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,960.00	346,898.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	100,000.00	100,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,683,900.00	5,685,900.00	
210807	Газрын төлбөр	50,000.00	341,550.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,307,180.06	161,131,229.44	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	68,100,206.00	78,939,820.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,024,900.00	2,430,650.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,182,074.06	79,760,759.44	
213	ҮРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,032,240,849.00	715,406,863.00	
2132	Бусад ургсал шилжүүлэг	1,025,822,700.00	704,681,680.00	
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг үдаагийн мөнгөн тэтгэмж	438,741,800.00	356,939,300.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	587,080,900.00	344,025,500.00	
213209	Нэг үдаагийн тэтгэмж, шагнал урамшуулалт	00.00	3,716,880.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,418,149.00	10,725,183.00	
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,418,149.00	10,725,183.00	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-26,510,246.24	422,530,491.37	
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,883,153.80	367,834,943.87	
225001	Үндсэн хөрөнгө худалсаны гарз	3,883,153.80	392,473.06	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	00.00	86,707,394.00	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал- Үндсэн хөрөнгө	00.00	280,735,076.81	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-3,883,153.80	-367,834,943.87	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-30,393,400.04	54,695,547.50	

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,820,259,547.00	1,586,278,630.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,820,259,547.00	1,586,278,630.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,754,475,500.00	1,483,448,400.00
131001	Ургал үйл ажиллагааны санхүүжилт	1,754,475,500.00	1,483,448,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,784,047.00	102,830,230.00
131103	ЗГНХ, ЗДНХ өргөнгөө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,760,000.00	13,032,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,000,000.00	30,780,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,024,047.00	59,017,480.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,799,176,547.00	1,580,857,901.00
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	1,799,176,547.00	1,580,857,901.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,935,698.00	865,451,038.00
2101	Цалин хөлөн нэмэгдэл урамшил	450,838,319.00	479,625,433.00
210101	Үндсэн цалин	333,775,148.00	359,578,546.00
210102	Нэмэгдэл	68,930,824.00	65,586,715.00
210103	Унаа холны хөнгөлөлт	21,406,000.00	29,271,000.00
210104	Урамшуулал	26,726,347.00	25,189,172.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,282,829.00	60,837,319.00
210201	Тэтгэврийн даатгал	36,184,636.00	41,586,825.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,701,401.00	4,892,569.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,590,034.00	3,878,214.00
210204	Ажилгүйдлийн даатгал	891,524.00	952,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,915,234.00	9,527,011.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	76,851,157.00	77,974,199.00
210301	Гэрэл, цахилгаан	5,841,235.00	6,389,060.00
210302	Түүщ халаалт	67,480,240.00	67,480,247.00
210303	Цэвэр, бохир ус	3,529,682.00	4,104,892.00
2104	Хангамж, бараа материалын зардал	62,128,727.00	59,044,088.00
210401	Бичиг хэрэг	5,090,980.00	5,020,100.00
210402	Тээвэр, шатахуун	49,387,000.00	45,920,600.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,468,688.00	2,289,938.00
210405	Хог хаягдал зайлтуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн зэлгэдэх, ахуйн эд зүйлс	5,032,059.00	5,693,450.00
2105	Нормативт зардал	18,263,000.00	31,294,321.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	15,925,000.00	29,184,821.00
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	2,338,000.00	2,109,500.00
2106	Эд хогшил, ургал засварын зардал	8,179,100.00	43,863,530.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,813,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,362,500.00	-
210604	Ургал засвар	6,816,600.00	40,050,530.00
2107	Томилолт, зочны зардал	7,575,700.00	10,943,700.00
210702	Дотоод албан томилолт	7,575,700.00	10,943,700.00

**Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		12,047,860.00	9,467,548.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		560,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		300,960.00	346,898.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		9,536,900.00	6,459,100.00
210807	Газрын төлбөр		50,000.00	341,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		76,769,006.00	92,400,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		74,566,106.00	90,318,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		2,202,900.00	2,082,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,032,240,849.00	715,406,863.00
2132	Бусад ургал шилжүүлэг		1,025,822,700.00	704,681,680.00
213207	Тэтгэврт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		438,741,800.00	356,939,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтвортой суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		587,080,900.00	344,025,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		-	3,716,880.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		6,418,149.00	10,725,183.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		6,418,149.00	10,725,183.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(3)=(1)-(2)	21,083,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН		(4)	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)			21,083,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ			21,083,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр			21,083,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		21,083,000.00	5,420,729.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)			(21,083,000.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)			-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			-

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үзүүлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үllэгдэл	983,841,471.77	3,495,439.29	-258,982,926.92	00.00	728,353,984.14
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	203,493.67	00.00	203,493.67
C03	Дахин илэрхийлсэн үllэгдэл	983,841,471.77	3,495,439.29	-258,779,433.25	00.00	728,557,477.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үзүүлгээний есэлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үзүүлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланда хүлээн зөвшөөрөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-30,393,400.04	00.00	-30,393,400.04
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үllэгдэл	1,097,766,471.77	240,639,297.24	-326,793,099.06	00.00	1,011,612,669.95
D01	2018 оны 12-р сарын 31-нээрх үllэгдэл	1,097,766,471.77	240,639,297.24	-326,793,099.06	00.00	1,011,612,669.95
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,178,089.79	00.00	1,178,089.79
D03	Дахин илэрхийлсэн үllэгдэл	1,097,766,471.77	240,639,297.24	-325,615,009.27	00.00	1,012,790,759.74
D04	Үндсэн хөрөнгийн дахин үзүүлгээний есэлт, бууралт	00.00	-1,178,089.79	00.00	00.00	-1,178,089.79
D05	Үндсэн хөрөнгийн есэлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланда хүлээн зөвшөөрөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	54,695,547.50	00.00	54,695,547.50
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үllэгдэл	1,097,766,471.77	239,461,207.45	-270,919,461.77	00.00	1,066,308,217.45

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Эдийн засгийн ангилаал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үзлэгэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛҮҮН ДҮН	1,754,475,500.00	1,748,077,351.00	1,483,448,400.00	1,472,827,217.00
21	ҮРСГАЛ ЗАРДАЛ	1,754,475,500.00	1,748,077,351.00	1,483,448,400.00	1,472,827,217.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	728,652,800.00	722,254,651.00	778,703,600.00	768,145,537.00
2101	Цалин холс болон нэмэгдэл урамшил	454,928,200.00	450,838,319.00	485,481,600.00	479,625,433.00
210101	Үндсэн цалин	291,713,800.00	333,775,148.00	341,064,500.00	359,578,546.00
210102	Нэмэгдэл	112,402,800.00	68,930,824.00	73,266,100.00	65,586,715.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,638,000.00	21,406,000.00	45,045,000.00	29,271,000.00
210104	Урамшуулал	28,173,600.00	26,726,347.00	26,106,000.00	25,189,172.00
2102	Ажил олгогчоos нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,591,500.00	54,282,829.00	63,185,200.00	60,837,319.00
210201	Тэтгэврийн даатгал	36,394,300.00	36,184,636.00	42,965,900.00	41,586,825.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,549,300.00	4,701,401.00	5,054,800.00	4,892,569.00
210203	ҮОМШӨ-ийн даатгал	3,639,400.00	3,590,034.00	4,043,900.00	3,878,214.00
210204	Ажилгүйцэлийн даатгал	909,900.00	891,524.00	1,011,000.00	952,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,098,600.00	8,915,234.00	10,109,600.00	9,527,011.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,691,400.00	76,851,157.00	80,215,100.00	77,974,199.00
210301	Гэрэд, цахилгаан	6,548,800.00	5,841,235.00	6,072,500.00	6,389,060.00
210302	Түлш, халаалт	67,480,200.00	67,480,240.00	67,480,200.00	67,480,247.00
210303	Цэвэр, бохир ус	4,662,400.00	3,529,682.00	6,662,400.00	4,104,892.00
2104	Хангамж, бараа материалын зардал	56,744,900.00	56,744,727.00	59,044,900.00	59,044,088.00
210401	Бичиг хэрэг	4,344,400.00	5,090,980.00	4,344,400.00	5,020,100.00
210402	Тээвэр, шатахуун	45,412,000.00	44,003,000.00	45,412,000.00	45,920,600.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,468,500.00	2,468,688.00	2,468,500.00	2,289,938.00
210405	Хог хаягдал зайлцуулах, хортон мэрггчийн устгал, ариутгал	1,020,000.00	150,000.00	1,320,000.00	120,000.00
210406	Бага үзүүтэй, тургэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	5,032,059.00	5,500,000.00	5,693,450.00
2105	Норматив зардал	18,263,000.00	18,263,000.00	18,263,000.00	18,262,321.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	16,159,000.00	15,925,000.00	16,159,000.00	16,152,821.00
210503	Нормын хувцас, зөвлөн эдлэл	2,104,000.00	2,338,000.00	2,104,000.00	2,109,500.00
2106	Эд хөгшил, ургал засварын зардал	28,239,100.00	28,239,100.00	35,859,100.00	35,859,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	460,000.00	4,040,000.00	5,362,900.00
210602	Тавилга	19,600,000.00	19,600,000.00	5,000,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,708,600.00	1,362,500.00	2,708,600.00	-
210604	Үргслал засвар	3,430,500.00	6,816,600.00	24,110,500.00	30,496,200.00
2107	Томилот, зочны зардал	7,575,700.00	7,575,700.00	6,575,700.00	6,575,700.00
210702	Дотоод албан томилот	7,575,700.00	7,575,700.00	6,575,700.00	6,575,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,560,000.00	12,410,860.00	13,020,000.00	12,908,377.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	560,000.00	560,000.00	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	1,500,000.00	1,500,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	350,000.00	300,960.00	350,000.00	346,898.00
210805	Тээврийн хэрэгслийн онцшилгоо	100,000.00	100,000.00	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,900,000.00	9,899,900.00	9,900,000.00	9,899,929.00
210807	Газрын төлбөр	50,000.00	50,000.00	350,000.00	341,550.00
210808	Банк, санхүүтийн байгууллагын үйлчилгээний хураамж	100,000.00	-	100,000.00	-

**Төв аймгийн Эрүүл мэндийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит**

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,059,000.00	17,048,959.00	17,059,000.00	17,059,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,976,100.00	14,966,059.00	14,976,100.00	14,976,100.00
210902	Хичээл үйлдвэрээлийн дадлага хийх	2,082,900.00	2,082,900.00	2,082,900.00	2,082,900.00
213	ҮРСГАЛ ШИЛДКҮҮЛЭГ	1,025,822,700.00	1,025,822,700.00	704,744,800.00	704,681,680.00
2132	Бусад ургтал шилжүүлэг	1,025,822,700.00	1,025,822,700.00	704,744,800.00	704,681,680.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	438,741,800.00	438,741,800.00	356,939,300.00	356,939,300.00
213208	Хөдөө орон нутагт тогтворт суурьшилтай ажилласан албан хаагчдад төреөс үзүүлэх дэмжлэг	587,080,900.00	587,080,900.00	344,025,500.00	344,025,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	3,780,000.00	3,716,880.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,754,475,500.00	1,754,475,500.00	1,483,448,400.00	1,483,448,400.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,754,475,500.00	1,754,475,500.00	1,483,448,400.00	1,483,448,400.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,754,475,500.00	1,754,475,500.00	1,483,448,400.00	1,483,448,400.00
4. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үзлэгдэл		-	-	-	-
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үзлэгдэл		-	-	-	-
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	45	52	45
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	41	34	41	34
620003	Үйлчилэх ажилтан	10	10	10	10

4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН	65,764,047.00	102,726,230.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,764,047.00	102,726,230.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,764,047.00	102,726,230.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,384,000.00	-
210402	Тээвэр, шатахувн	5,384,000.00	-
2105	Нормативт зардал	-	13,032,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	13,032,000.00
2106	Эд хогшил, ургсал засварын зардал	-	9,554,330.00
210604	Ургсал засвар	-	9,554,330.00
2107	Томилолт, зочны зардал	-	4,368,000.00
210702	Дотоод албан томилолт	-	4,368,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,380,047.00	75,771,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	60,260,047.00	75,771,900.00
210902	Хичээл үйлшвэрлэлийн дадлага хийх	120,000.00	-
II	ЗАРДЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,784,047.00	102,830,230.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,784,047.00	102,830,230.00
131103	ЗГНХ ЗДНХеренгэ, түүнтэй адилтгах ангилагдаагүй неец хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,760,000.00	13,032,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт гусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,000,000.00	30,780,750.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,024,047.00	59,017,480.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (Ш)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		